

**ӨСВӨР НАСНЫ ХҮНД ОНОГДУУЛСАН ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛ
ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГАА**

**INTERNATIONAL STANDARDS ON OTHER PENALTIES FOR JUVENILE
PERSONS**



Д.Одсэр

*Дотоод хэргийн их сургуулийн докторант,
хурандаа*

Товч утга: Өгүүлэлд өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан олон улсын хэм хэмжээний ойлголт, төрөл, ангилалын талаар тайлбарласан.

Түлхүүр үгс: хорихоос өөр төрлийн ял, өсвөр насны хүн, олон улсын хэм хэмжээ, хяналт.

Abstract: The article describes the concepts, types, and classifications of international norms that other penalties for juvenile persons.

Keywords: non-custodial sentences, juveniles, international norms and controls.

Өсвөр насны хүний гэмт явдал нь нийгмийн тусгайлсан динамик үзэгдэл бөгөөд нийт гэмт явдлын хувьд аюултай “нөөц” гэж хэлж болох юм. Хууль зөрчигчийн насанд хүрээгүй байдлыг гэмт үйл хэрэгтэй тэмцэхэд чиглэсэн эрүүгийн эрх зүйн арга хэмжээний онцлогууд тодорхойлдог гадна нийгмийн, насны, сэтгэл зүйн болон бие бялдрын шинж чанараас хамаарсан энэ төрлийн иргэдэд хандах онцгой хандлага ч тодорхойлдог байна.

Урт хугацаанд хорих ялыг гэмт үйл явдалтай тэмцэх олон талт арга хэмжээнүүдийг нэг гэж үзэж байсан. Үүнтэй зэрэгцэн хууль зүйн шинжлэх ухаанд энэ төрлийн ялын үр нөлөөнд нэг бус удаа үнэлгээ хийсэн байдаг.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын эрүүгийн болон эрүүгийн шийдвэр гүйцэтгэх бодлогод ялын цээрлүүлэх байдлыг зөөлрүүлж хүмүүжүүлэх арга

барилыг баримтлах, эрүүгийн хэргийн шүүхээс насанд хүрээгүй хүмүүст хорихоос өөр төрлийн ялыг түлхүү оногдуулах болсон нь энэ төрлийн хоригдлын тоо буусан үзүүлэлттэй болоход нөлөөлсөн байна. Ял эдлүүлэх нөхцөлийг энэрэгүй болгох чиглэл нь Засгийн газрын бодлого, хөтөлбөр, Хүний эрхийн комиссоос баримталж буй чиглэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөгжлийн стратеги зэрэгт тусгалаа олсон байдаг.

Гэсэн хэдий ч өсвөр насны хоригдлын тоо буурсан ч эдгээр хүмүүсийн давтан гэм хэрэг үйлдэх явдал 10 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх онолын үндэс, эрх зүйн зохицуулалт, практикийг дэлгэрэнгүй судлан авч үзэхэд зарим тохиолдлыг эс тооцвол ял эдлүүлэх ажиллагаанд ямар нэгэн онцлог байхгүй байна.

Энэ асуудлын хүрээн дэх олон улсын хамтын ажиллагаа нь насанд хүрээгүй хүнд эрүүгийн ял оногдуулах, түүнийг хэрэгжүүлэхэд хамаарсан олон улс, орнуудын туршлагад суурилсан суурь олон улсын баримт бичгийг боловсруулахад хүргэсэн. Үүнтэй холбогдуулан бидний судалж буй салбарын хүрээнд олон улсын баримт бичиг боловсруулах Нэгдсэн Үндэсний Байгууллагын голлох чиг үүрэг болсон юм.

Бидний судалж буй өсвөр насны хүний онцлогийг тодруулахын зэрэгцээ олон улсын байгууллагаас гэмт хэрэгт сэжиглэгдэж буй, буруутгагдаж буй, ял эдлэж буй насанд хүрээгүй хүмүүст хамаарах олон улсын баримт бичгийг боловсруулсан юм. Тэр дундаас Хүүхдийн эрхийн тунхаглал 1959 он, Хүүхдийн эрхийн тухай конвенци 1989 он.

Насанд хүрээгүй хүнд оногдуулах эрүүгийн ял нь олон улсын баримт бичгийн зарчимд бүрэн нийцсэн байх учиртай. Гэсэн хэдий ч дээр дурдсан олон улсын актууд нь өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ялыг эдлүүлэх ажиллагааг зохицуулаагүйг тэмдэглэх хэрэгтэй.

Токиогийн дүрмүүдийг боловсруулах гол учир нь хорих ялыг орлох өөр ялын төрлийн хэрэглэхэд оршисон. Энэ дүрмүүдэд хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүний баталгаа, эрх, хууль ёсны ашиг сонирхол зэргийг агуулдаг. Хорихоос өөр төрлийн ялыг ялтны хувийн байдал, түүнчлэн хохирогчийн эрх, шийтгэлийн зорилгод нийцэн тогтоогдсон шалгууруудад үндэслэн ялын төрлийг сонгодгийг тэмдэглэх хэрэгтэй¹.

Дүрмүүд нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэх, ялангуяа эрх зүйн зөрчил үйлдэгчдэд хандахад олон нитийн илүү идэвхтэй

¹ Токиогийн дүрмүүдийн 3.2 дугаар дүрэм.

оролцоог хангах, түүнчлэн эрхийн зөрчил гаргачид нийгмийн өмнө хариуцлага хүлээх мэдрэмжийг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх зорилгыг агуулдаг байна.

1990 оны Токиогийн дүрмүүдэд ялтанд тавих хяналтын гол зорилго нь давтан гэмт хэргийг бууруулах, нийгмийн амьдралд нь дэмжлэг үзүүлэхэд оршино гэж заасан.

Шаардлагатай тохиолдолд өсвөр насны ялтанд нийгмийн, сэтгэл зүйн болон хууль зүйн дэмжлэг үзүүлдэг байна. Өсвөр насны хүнд оногдуулсан үүрэг, хязгаарлалт нь түүний, хохирогчийн болон нийгмийн ашиг сонирхлыг харгалзан үзсэн тодорхой байх ёстой. Ялын зорилгод хугацаа дуусахаас өмнө хүрсэн тохиолдолд хорихоос өөр төрлийн ялаас хугацаанаас өмнө суллагдах боломжтой байдаг.

Токиогийн дүрмүүдэд ялтнуудад бүлгийн болон ганцаарчилсан сургалтыг зохион байгуулах арга зүйг боловсруулахдаа төрөл бүрийн хууль зөрчигчидтэй тусгайлан харьцах хэрэгтэй болохыг заавал харгалзан үзэх нь оновчтой гэж тэмдэглэсэн байна.

Хэрэг ялтан оногдуулсан ялыг эдлүүлэх журмыг зөрчсөн тохиолдолд ялыг зогсоох эсхүл өөр ялаар сольдог байна. Хэрэв ялтанд үзүүлэх ялын үр нөлөө үнэхээр бага байгаа бол нэн даруй хорих ялаар солих зөвлөмжийг олон улсын баримт бичгүүдэд тусгасан байдаг.

Шүүхээс хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн өсвөр насны хүнд хяналт тавьж байгаа албан хаагч нь ялтан бүрийн засрал хүмүүжлийн түвшинд үнэлгээ өгөх чадвар бүхий мэргэжлийн бэлтгэлжилттэй байх ёстой.

Үүний зэрэгцээ олон улсын баримт бичигт тусгагдсан зөвлөмжийг үл тоох хэрэггүй бөгөөд үндэсний хууль тогтоомждоо аль боломжтой байдлаар тусгах хэрэгтэй гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

Өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан олон улсын баримт бичгийг судлахын зэрэгцээ Европын Холбооны “Насанд хүрээгүй хүнд хэрэглэсэн эрүүгийн эрх зүйн шинжтэй арга хэмжээний талаар Европын дүрмүүд”ийг судлах хэрэгтэй. Энэ дүрмүүдийг 2008 онд Бээжингийн болон Токиогийн дүрмүүдийн заалтуудыг харгалзан үзэж боловсруулсан бөгөөд өсвөр насны гэмт хэрэгтэнд хэрэглэх нийгмийн санкци, арга хэмжээнүүдийн үндсэн зарчмууд, эрх зүйн хэм хэмжээг тогтоосон байна. Нийгмийн санкцид таслан сэргийлэх арга хэмжээнээс бусад өсвөр насны хүнд эрх чөлөөтэй, тодорхой хязгаарлалтыг дагаж мөрдөх аливаа арга хэмжээг хэлнэ гэж баримт бичигт дурдсан байна.

Иймд, өсвөр насны хүний насны ангиллыг харгалзсан хорихоос өөр төрлийн ялын олон сонголттой байхыг улс орнуудад зөвлөсөн байдаг байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын зорилгыг "Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэсэн байна" гэж Эрүүгийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-т заасан эрүүгийн хариуцлагын нийтлэг зорилгоос тусад нь тусгайлан хуульчилсан.


Өсвөр насны хүнд оногдуулах ял, түүнийг оногдуулах үндэслэл, тусгай журмыг өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын зорилгод нийцүүлж, түүнийг нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлахад чиглүүлэн хуульчилсан.

Эрүүгийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т зааснаар гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүнд нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ялыг оногдуулдаг.

Өсвөр насны хүнд нийтэд тустай ажил хийлгэх ялыг эдлүүлэхдээ түүний бие бялдар, оюун санааны хөгжилд ачаалал өгөхгүй байхаас гадна, тухайн ажлын байранд "халамжлан хүмүүжүүлэгч", эсхүл "багш"-тай хамт байлгавал үр нөлөөтэй гэж үзэж байна.

Өсвөр насны хүний хөдөлмөр бол нийгэм дэх хөдөлмөрийн өвөрмөц төрөл юм. Өсвөр насны хүнээр халуун, хүйтэнд хот тохижилтын ажил хийлгэвэл тэдгээрийн оюун санаа, бие бялдар, эрүүл мэндийн хувьд таагүй нөлөө үзүүлж болох талтай.

Зураг.1. Шүүхээс өсвөр насны хүнд ял оногдуулсан судалгаа



Шүүхээс 2019 онд гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүдийн 26.5%, 2020 онд 23%, 2021 онд 13.5% тус тус ял оногдуулсан байна. Мөн 2019 онд өсвөр насны хүнд оногдуулсан нийт ялын 15%, 2020 онд өсвөр насны хүнд оногдуулсан нийт ялын 16.6%, 2020 онд өсвөр насны хүнд оногдуулсан нийт ялын 15.2% нийтэд тустай ажил хийлгэх ял тус тус эзэлж байна. Дээрх үзүүлэлтээс харахад жил ирэх тусам шүүхээс өсвөр насны хүнд ял оногдуулах байдал буурсан үзүүлэлттэй байна.

Нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэхтэй холбоотойгоор "Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтныг ажиллуулах байгууллагын жагсаалт"-ыг баталсан хэдий ч "нийтэд тустай ажил" гэдэгт ямар ажил, үйлчилгээг хамааруулах, үүнээс алийг нь өсвөр насны хүнээр хийлгэх боломжтой гэдгийг тодорхойлж, нарийвчлан зохицуулаагүй байна.


Улс орнууд нийтэд тустай үйл ажиллагааны төрлүүдийг жагсааж, эсхүл нийтийн тусын тулд чиглэсэн нийтэд тустай үйл ажиллагааг тодорхойлох шалгуурыг гарган хуульчилж байна. Ялангуяа нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгэл хүлээсэн этгээдийн гүйцэтгэх ажил, үйлчилгээ нь хэн нэгэн этгээдийн бизнесийн болон хувийн ашиг сонирхлыг хангахад чиглэвэл уг ялын мөн чанар алдагдахал хүрэх юм. Тиймээс манай улсын хувьд өөрийн хөгжлийн түвшин, үндэсний онцлогт нийцүүлэн нийтэд тустай ажил, үйлчилгээний төрлүүдийг судалж, нийгмийн аль салбар, үйл ажиллагааг хамруулах асуудлыг оновчтой тодорхойлж, зохицуулах нь чухал байна.

Зорчих эрхийг хязгаарлах ялын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр зүй зохистой, зөв амьдралд ороход туслалцаа үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин гэмт хэрэг үйлдэх зан үйлээс нь татгалзуулах, урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн хохирогч, бусад хүнийг хамгаалахад оршдог.

Зорчих эрхийг хязгаарлах ялыг гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүнд оногдуулахдаа

Эрүүгийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д заасан хугацааг хоёр дахин багасгаж оногдуулахаар хуульчилсан.

Зураг.2. Өсвөр насны хүнд оногдуулсан зорчих эрхийг хязгаарлах ялын 2021-2022 оны 08 дугаар сар хүртэлх бодит биелэлт



Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд ашиглагдаж буй цахим бугуйвч нь “хориглосон бүсэд нэвтрэх”, “хязгаарласан бүсээс гарах”, “бүсийн хязгаарт ойртсон”, “явах маршрутаас гарсан” зэрэг тохиолдолд цахим бугуйвчид анхааруулах мессеж илгээх болон “Цахим хяналт, удирдлагын төв”-ийн “хяналтын нэгдсэн систем”-д 24 цагийн турш тасралтгүй “анхааруулга, дохио” дамжуулах горимоор ажилладаг.

Дээр дурдсанаас үндэслэн өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг дараахь нөхцөл байдлыг харгалзан сайжруулах хэрэгтэй байгаа нь харагдаж байна.

Нэгдүгээрт, насанд хүрээгүй хүний бие сэтгэл зүйн онцлог нь албадлагын аливаа төрлийн арга, тэр дундаа эрүүгийн хариуцлагыг хэрэгжүүлэх онцгой журмыг тодорхойлсон байдаг. Энэ үзэл санаа насанд хүрээгүй хүмүүсийн бие сэтгэл зүйг судалсан эрдэмтдийн судалгаануудаар нотлогддог.

Хоёрдугаарт, насанд хүрээгүй хүнийг эрүүгийн ял эдлүүлэх практик нь дээр дурдсан онцлогийг харгалзан илүү нягт, дэлгэрэнгүй эрх зүйн зохицуулалт хэрэгтэйг харуулсан.

Дурдсан нөхцөл байдал нь нэг талаас эрүүгийн ял эдлүүлэх байгууллагын хууль хэрэгжүүлэх үйл ажиллагаа, насанд хүрээгүй хүний ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байгааг харуулж байгаа бөгөөд энэ нь судалгааны ажлын үндэслэл болсон.

Өвсөр насны хүнийг хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны олон улсын хэм хэмжээ, гадаадын зарим орны онцлог

Насанд хүрээгүй хүний гэмт явдал нь дийлэнх нь орнуудын анхаарлын төвд байдаг асуудлуудыг нэг юм.

Э.Б. Мельникова “насанд хүрээгүй хүн” гэж өөрийн наснаас хамааран амьдралд хүлээн зөвшөөрөгдөхгүйгээс шалтгаалан тодорхой онцлог бүхий эрх, үүрэгтэй бүлэг хүмүүсийг хэлдэг бөгөөд тэдний эрхийг хамгаалах эрх зүйн тогтвортой үндэсийг боловсруулах шаардлагатай гэж үзсэн¹.

Голландын насанд хүрээгүй хүмүүсийн шударга ёсны тогтолцоог судлан үзье. Энэ тогтолцоо нь 1905 онд Хүүхдийн тухай эрүүгийн хууль (Penal Children's Act) батлагдсанаас эхтэй бөгөөд насанд хүрээгүй хүнд шударга ёсыг тогтоох тусгайлсан хэм хэмжээг тусгасан байна. Дараагаар нь энэ хэм хэмжээнүүд Голландын Эрүүгийн хуульд тусгалаа олсон байна. Сурган хүмүүжүүлэх шинжийг агуулсан Насанд хүрээгүй хүмүүсийн шударга ёсны тогтолцоог заасан байна².

Насанд хүрээгүй хүний хэргийн шүүхээс өвсөр насны хүнийг буруутай гэж үзсэн бол нэг эсхүл хэд хэдэн тусгайлсан ялыг оногдуулж болдог. Голландад Улсад өвсөр насны гэмт хэрэгтэнд дараах эрүүгийн хариуцлагыг оногдуулдаг: нийтэд тустай ажил, сургалтын төсөл. Энэ ялаас тусдаа эсхүл нэмэгдүүлж торгууль оногдуулж болно³. Иймд, Голланд Улсын хууль тогтоомжид зааснаар хорихоос өөр төрлийн ялд нийтэд тустай ажил, сургалтын хөтөлбөр, торгох ял хамаардаг байна.

Нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагааг пробацын алба хариуцдаг. Мөн Голландад Улсад ял эдлүүлэх ажиллагааны нэг чухал онцлог нь ялтны хувийн байдаг байдгийг онцлох хэрэгтэй. Жишээ нь, нэг байгууллага нь мансуурах донтой хүнтэй ажилладаг (Stichting Verslavingserclassering GGZ), нөгөө байгууллага нь бусад гэмт хэрэгтнүүдтэй (Reclassering Nederland) ажилладаг байна. Харин зөвхөн нэг байгууллага нь

¹Мельникова Э.Б. Ювенальная юстиция. Проблемы уголовного права, уголовного процесса и криминологии : учеб. пособие. М., 2000. 11 дэх тал.

² Alternatives to custody for young offenders and the Influence of foster care in European Juvenile Justice. The Netherlands / editors: Andrea Păroșanu, InekePruin, Joanna Grzywa-Holten, Philip Horsfield. URL: http://eigep.eu/wp-content/uploads/2018/01/2014_comparative_report_alternatives_to_custody_for_young_offenders.pdf (

³ Government of the Netherlands. URL: <https://www.government.nl/topics/sentences-and-non-punitive-orders/penalties-juvenile-offenders>

(Reclassering Nederland)нийтэд тустай ажил хийлгэх тусгайлсан нэгжийг байгуулахаар шийдвэрлэсэн байдаг¹.

Нийтэд тустай ажлыг улсын болон хувийн байгууллагад хийлгэдэг. Тусгайлсан хөтөлбөрөөс гадна зарим төрлийн ялтнуудад хамааралтай бүлгийн хөтөлбөр ч байдаг. Нийтэд тустай ажлын ажлын болон амралтын өдөр хийлгэх нь мөн ялгаатай. Голланд Улсад нийтэд тустай ажлын түгээмэл төрөл нь орчны цэвэрлэгээ, цэцэрлэгжүүлэлт байдаг. Өсвөр насны ялтан нийтэд тустай ажил хийхээс зайлсхийсэн тохиолдолд ямар нэгэн шүүх ажиллагаагүйгээр прокурор ялын нөхцөлийг өөрчлөх боломжтой.

Өсвөр насны хүн түүнд оногдуулсан торгуулийг төлөөгүй тохиолдолд ялыг баривлах эсхүл нийтэд тустай ажил хийлгэх ялаар солидог. Ингэхдээ баривчлах ялын хугацаа гурван сараас дээшгүй байх, эсхүл төлөөгүй мөнгөн дүнгийн хэмжээнээс хамаарч нийтэд тустай ажил хийлгэдэг байна². Зарим судлаачид энэ нөхцөлийг хэт хатуу гэж үздэг.

Их Британид өсвөр насны хүмүүсийн гэмт явдлаас урьдчилан сэргийлэх улсаас боловсруулсан төрөл бүрийн хөтөлбөрүүд байдаг байна. Энэ дундаас эцэг эх эсхүл хууль ёсны төлөөлөгчдөд зориулсан хөтөлбөрийг онцолж болох юм. Энэ хөтөлбөрийн нэг хэсэг нь эцэг эхийн ур чадварыг нэмэгдүүлэх, өсвөр насны хүнийг гэмт хэрэг үйлдэхэд хүргэж болох гэр бүлийн сөрөг уур амьсгал, нөхцөл байдлыг илрүүлэх байж болдог³.

Улс орнууд олон улсын стандартад тавигдаж байгаа шаардлагуудыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ эдгээрийг бүрэн дагаж мөрдөх нөхцөлүүдийн нэг бол өсвөр насны хүнд хорих ял оногдуулахыг аль болох багасгаж, хорихоос өөр төрлийн ялыг түлхүү оногдуулах хэрэгтэйг онцолсон байдаг. Өсвөр насны хүмүүсийн гэмт явдалтай тэмцэхэд цогц хандлага маш ойлгомжтой бөгөөд гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа өсвөр насны хүнийг саатуулахаас

¹ Miranda Boone Only for minor offences: Community Service in the Netherlands // European Journal of Probation University of Bucharest. Vol. 2. № 1. 2010. P. 30. URL: https://www.researchgate.net/profile/Miranda_Boone/publication/238713745_Only_for_Minor_Offences_Community_Service_in_the_Netherlands/links/56ec2afa08aee4707a385347/Only-for-Minor-Offences-Community-Service-in-the-Netherlands.pdf

² Alternatives to custody for young offenders and the Influence of foster care in European Ju-venile Justice. The Netherlands / editors: Andrea Păroșanu, InekePruin, Joanna Grzywa-Holten, Philip Horsfield. URL: http://eigep.eu/wp-content/uploads/2018/01/2014_comparative_report_alternatives_to_custody_for_young_offenders.pdf

³ United Kingdom government. URL: <https://www.gov.uk/youth-crime-prevention-programmes/involving-parents-and-families>

эхлээд ял эдэлж дууссаны дараа ч дахин нийгэмшүүлэх зорилгодоо хүрэх хүртлээ зохион байгуулах хэрэгтэй юм.

Цаашлаад бид Тусгаар улсуудын нөхөрлөлийн орнуудад өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг судлан үзье. Эдгээр орнуудын эрүүгийн хууль тогтоомжид тоо, өсвөр насны хүнд оногдуулах төрлийн хувьд адилгүй хорихоос өөр төрлийн ялыг заасан байдаг.

Армени Улсын Эрүүгийн хуульд¹ хоёр төрлийн хорихоос өөр төрлийн ялыг хуульчилсан: торгох ял болон нийтэд тустай ажил хийлгэх ял. Беларусь² болон Казахстан³ Улсын Эрүүгийн хуулиудад бусад орнуудтай харьцуулахад өсвөр насны хүнд оногдуулах илүү олон төрлийн ялыг тусгасан байдаг. Хамгийн өргөн хэрэглэгддэг нь торгох ял, нийтэд тустай ажил, арай бага хэрэглэгддэг нь тодорхой албан тушаал эрхлэх эрхийг хасах юм.

Тусгаар Улсуудын нөхөрлөлийн дийлэнх орнуудад (Азербайджан, Армени, Беларусь, Казахстан, Киргиз, Тажикистан, Туркменистан) зөвхөн өөрийн орлоготой өсвөр насны хүнд торгох ял оногдуулдаг⁴. Торгох ял шийтгүүлсэн өсвөр насны ялтан хуульд тогтоосон хугацаанд торгуулиа төлж дуусгах ёстой. Азербайджан Улсад (Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн 23дүгээр зүйл), Киргиз Улсад (Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн 59дүгээр зүйлийн 1 дэх хэсэг) нэг сарын хугацааг, Туркменистанд гурван сарын хугацааг (Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн 25дугаар зүйлийн 1 дэх хэсэг) тогтоодог. Казахстан Улсын хууль тогтоомжид (Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн 50дугаар зүйлийн 1 дэх хэсэг)⁵ торгууль төлөх хугацааг шүүхээс тодорхойлохоор заасан.

¹ Уголовный кодекс Республики Армения от 18 апреля 2003 г. (ред. от 22.01.2020) // Официальный сайт Национального Собрания Республики Армения. URL : <http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=1349&lang=rus>

² Уголовный кодекс Республики Беларусь от 9 июля 1999 г. (ред. от 14.04.2021) // Национальный правовой интернет-портал Республики Беларусь. URL: <https://pravo.by/document/?guid=3871&p0=Hk9900275>

³ Уголовный кодекс Республики Казахстан от 3 июля 2014 г. (ред. от 02.01.2021) // Информационно-правовая система нормативных правовых актов Республики Казахстан. URL: <http://adilet.zan.kz/rus/docs/K1400000226>

⁴ Пономарев С. Н., Карханина Л. В. Сравнительно-правовой анализ применения штрафа к несовершеннолетним в Российской Федерации и в странах Союза Независимых Государств // Вестник Московского государственного областного университета. Сер. Юриспруден-ция. 2019. № 4. С. 43.

⁵ Уголовно-исполнительный кодекс Республики Казахстан от 5 июля 2014 г. (в ред. 19 января 2021 г.) // Информационно-правовая система нормативных правовых актов Республики Казахстан. URL: <http://adilet.zan.kz/rus/docs/K1400000234>

Тусгаар Улсуудын нөхөрлөлийн дийлэнх орнуудад эдгээр ялыг эдлэхээс зайлсхийсэн тохиолдолд гарах эрх зүйн үр дагавар нь харилцан адилгүй. Жишээ нь, ОХУ-д хуулиар тогтоосон хугацаанд торгуулиа төлөөгүй ялтныг санаатайгаар зайлсхийсэнд тооцдог (Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн 32дугаар зүйл). Ингэхдээ торгох ялыг илүү хүнд төрлийн ялаар солих боломжийн талаар мэдэгдэл гаргадаггүй байна. Харин Беларусь Улсын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн 30дугаар зүйлийн 2 дахь хэсэгт эсэргээрээ мэдэгдэл гаргана гэж заасан байдаг¹. Беларусь Улсын хууль тогтоомжид хэрэв ялтан түүнд хүргүүлсэн мэдэгдэл хүргүүлсний дараа торгуулиа төлөх боломжгүй, төлөхөөс зайлсхийсэн шинж байхгүй торгох ялыг нийтэд тустай ажил хийлгэх ял эсхүл хүмүүжлийн чанартай албадан ажлаар солих хоёр хувилбарыг тусгасан(Беларусь Улсын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн 32дугаар зүйл).

Дээр дурдсанчлан өсвөр насны гэмт хэрэгтэнд бага хэмжээгээр оногдуулдаг хорихоос өөр төрлийн ялын төрөл нь тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах ял юм. Энэ ялыг гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд үндсэн эсхүл нэмэгдэл ямаар Беларусь Улсад (Эрүүгийн хуулийн 48 дугаар зүйл), Тажикистан Улсад (Эрүүгийн хуулийн 48 дугаар зүйл), нэмэгдэл ялаар Казахстан Улсад оногдуулдаг байна (Эрүүгийн хуулийн 40 дүгээр зүйл).

ДҮГНЭЛТ

1. Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэгдсэн байдаг.

2. Гадаадын орнуудад өсвөр насны гэмт хэрэгтэнд оногдуулдаг хорихоос өөр төрлийн ялын талаар судлан үзээд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Их Британид эцэг эхийн ур чадварыг нэмэгдүүлэх, өсвөр насны хүнийг гэмт хэрэг үйлдэхэд хүргэж болох гэр бүлийн сөрөг уур амьсгал,

¹ Уголовно-исполнительный кодекс Республики Беларусь от 11 января 2000 г. (в ред. от 10 декабря 2020 г.) // Информационно-поисковая система «ЭТАЛОН-ONLINE». URL: <https://etalonline.by/document/?regnum=НК0000365>

нөхцөл байдлыг илрүүлэхэд чиглэглэгдсэн хөтөлбөрүүдийг өргөнөөр ашигладаг байна;

- Беларусь Улсад Эрүүгийн ял эдлүүлэх хуульд торгуулиа төлөхөөс зайлсхийсэн ялтанд мэдэгдэл хүргүүлэх талаар заасан байдаг. Өсвөр насны хүнд нөлөөлөх энэ төрлийн арга хэмжээ нь ялаа эдлэх, торгох ялыг хугацаа алдалгүй өөр төрлийн ялаар солиход ач холбогдолтой;

- Казахстан Улсад засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг зөвхөн өөрийн гэсэн орлоготой өсвөр насны хүнд оногдуулдаг. Учир нь хууль ёсны дагуу ажил хийж байгаа өсвөр насны хүмүүс ял эдлэхээсээ өмнө өөрийн хүслээр ажил хийхээ илэрхийлсэн байдаг бөгөөд эдгээр хүмүүст засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял оногдуулахад ялаа эдлэх магадлал нэмэгддэг байна;

- Беларусь Улсын өсвөр насны ялтны нийтэд тустай ажил хийх хугацааг хичээл, сургалт, хөдөлмөрөөс хамааран зохицуулдаг байна.

3. Өсвөр насны хүнд оногдуулсан нийтэд тустай ажил хийлгэх ялын талаар судлан үзэхэд сүүлийн жилүүдэд тус төрлийн ялыг шүүхээс оногдуулах нь тодорхой хэмжээгээр багассан үзүүлэлттэй байна.

Үүнээс гадна хэд хэдэн асуудлыг ч нээн илрүүллээ. Тухайлбал:

-Нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэхтэй холбоотойгоор "Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтныг ажиллуулах байгууллагын жагсаалт"-ыг баталсан хэдий ч "нийтэд тустай ажил" гэдэгт ямар ажил, үйлчилгээг хамааруулах, үүнээс алийг нь өсвөр насны хүнээр хийлгэх боломжтой гэдгийг тодорхойлж, нарийвчлан зохицуулаагүй байна.

- Нийтэд тустай ажил хийлгэх байгууллагуудын жагсаалтыг заасан хэдий ч ялтнаар хийж гүйцэтгүүлэх ажлын талаар заагаагүй.

-Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, хүүхдийн сэтгэцийн хөгжилд харшлахгүй нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулахаар заасан ч өсвөр насны хүний нас, бие, эрүүл мэнд, ёс суртахуун, хүүхдийн сэтгэцийн хөгжилд харшлах эсэхийг тодорхойлох эрх бүхий субъект нь тодорхойгүй байна.

Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийн хувьд зорчих эрхийг хязгаарлах ялыг гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүнд оногдуулахдаа Эрүүгийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д заасан хугацааг хоёр дахин багасгаж оногдуулахаар хуульчилсан байна.

Зорчих эрхийг хязгаарлын ялын гүйцэтгэлийн хувьд насанд хүрсэн хүнд оногдуулсан ялтай харьцуулахад харьцангуй өндөр байгаа харагдаж байна. Гэсэн хэдий ч оногдуулсан ялыг хорих ялаар сольсон тохиолдол байгаа нь өсвөр насны хүнээс гаргаж байгаа нь ноцтой зөрчил байгааг харуулж байна.

---o0o---